


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

07.06 - 07.10



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй хаагдлаа. Технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq индекс Amazon, com, Apple, Facebook болон Netflix компаниудын хувьцааны ханш өссөнтэй холбоотой дээд түвшиндээ хүрсэн байна. Мөн Facebook болон Netflix компаниудын хувьцааны ханшийн өсөлттэй холбоотой S&P 500 индексээс харилцаа холбооны салбар хамгийн их өсөлттэй байсан бол нефтийн үнэ баррель тутамдаа 40 ам.доллороос буурсантай холбоотой эрчим хүчний салбар хамгийн их уналттай байлаа.

Даваа гарагийн арилжаагаар АНУ-ын хөрөнгийн зах зээл өсөлттэй байсан ба COVID-19-ийн эсрэг вакцин энэ оны эцэс гэхэд гарах магадлалтай байгаа нь энэ өсөлтийн шалтгаан болсон байна. Гэвч дараагийн өдрүүдээс COVID-19 цар тахлын эсрэг авсан арга хэмжээнүүдийн үр дүн үгүй болсонтой холбоотой зах зээл уналтад орж эхэлжээ. Олон мужууд COVID-19-ийн шинэ тохиолдол болон эмнэлэгт хэвтэгсдийн тоо нэмэгдэж байгааг мэдэгдсэн бөгөөд зарим мужийн засаг дарга нар нэмэлт хязгаарлалтын арга хэмжээ авах мөн хөл хориог цуцлах үйл ажиллагаануудаа хойшлуулахаа мэдэгдэв.

Европ: Энэ долоо хоногт COVID-19-ийн тохиолдлын тоо огцом нэмэгдсэнтэй холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлтгүй хаагдлаа. Европын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэдэг STOXX Europe 600 индекс хөдөлгөөнгүй хаагдсан ч бусад томоохон индексүүд холимог үзүүлэлттэй байлаа. DAX индекс 0.22%-аар өссөн бол CAC-40 индекс 1.38%-аар, FTSE MIB индекс 1.12%-аар, FTSE 100 индекс 1.19%-аар тус тус буурсан байна.

Эдийн засгийн сэргэлттэй холбоотой долоо хоногийн эхээр бондуудын өгөөж сэргэж эхэлсэн ч коронавирустай холбоотойгоор долоо хоногийн сүүл гэхэд бондуудын өгөөж дахин буурсан байна. АНУ-д вирусийн тохиолдлууд нэмэгдэж байгаа нь вирусийн хоёр дахь давлагааны айдсыг үүсгэжээ. Ингэснээр хөрөнгө оруулагчид эрсдэл багатай хөрөнгүүдийг их хэмжээгээр худалдан авч Евро бүсийн бондын зах зээлийн голлох бондуудын өгөөж буурахад хүргэлээ.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд харьцангуй уналт багатай байлаа. Nikkei 225 индекс 16 пункт буюу 0.07%-аар буурч 22,290.81 нэгж хүрсэн ба зах зээлийг ерөнхийд нь илтгэгч TOPIX индексүүд мөн бага хэмжээний уналттай хаагдсан байна.

2019 оны 5-р сарын 31-ээр төгсгөл болсон 2019 оны санхүүгийн жилд Япон улс нийт 58 их наяд юанийн (540 тэрбум ам.доллар) татварын орлого олсон байна. Энэ нь 2018 оны санхүүгийн жилийнхтэй харьцуулахад 3.2%-аар буурсан байна гэж Япон улсын Сангийн яам мэдэгджээ.

БНХАУ: БНХАУ-ын эдийн засаг эргэн сэргэсэнтэй холбоотой БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй хаагдлаа. Баасан гараг гэхэд CSI 300 индекс 7.5%-аар өссөн бол Shanghai Composite индекс 7.3%-аар өссөн байна. БНХАУ-ын тогтмол орлоготой үнэт цаасны зах зээл дээр дотоодын бондуудын ханш бууран өгөөж өссөн байна. БНХАУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж, эдийн засаг эргэн сэргэсэн болон хувьцааны зах зээл дахин өсөлт үзүүлж эхэлсэнтэй холбоотой 20 функтаар нэмэгдэж 3.13% хүрсэн байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,427.63	-0.42% ▼
Dow Jones	АНУ	26,075.30	0.96% ▲
S&P 500	АНУ	3,185.04	1.76% ▲
Nasdaq	АНУ	10,617.44	4.01% ▲
S&P/TSX	Канад	15,713.82	0.75% ▲
FTSE 100	Их Британи	6,095.41	-1.01% ▼
S&P/ASX 200	Австрали	5,919.20	-2.29% ▼
Nikkei 225	Япон	22,290.81	-0.07% ▼
Hang Seng	Хонг Конг	25,727.41	1.40% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	109.28
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.69
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.09
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.37
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.73
DBM' 2023	USD	7.250%	101.27
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	90.08

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.175	0.08 ▲
Libor 3M	0.268	-0.03 ▼
Libor 6M	0.345	-0.06 ▼
Libor 1YR	0.480	-0.05 ▼
US 2YR Bond	0.165	0.06 ▲
US 3YR Bond	0.195	0.05 ▲
US 5YR Bond	0.307	0.03 ▲
US 10YR Bond	0.645	-0.06 ▼

Валютын ханш	2020.07.10	Өөрчлөлт
USD	2,832.22	0.22% ▲
CNY	404.12	1.05% ▲
EUR	3,194.46	0.61% ▲
RUB	39.83	-0.60% ▼
KRW	2.36	0.00%
JPY	26.51	0.84% ▲
CAD	2,080.98	-0.17% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,798.70	1.50% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	18.72	3.91% ▲
Зэс	USD/lb.	289.75	6.14% ▲
Нүүрс	USD/MT	53.98	-0.53% ▼
WTI газрын тос	USD/bbl.	40.55	0.27% ▲
Brent газрын тос	USD/bbl.	43.24	1.03% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	1.81	3.43% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.V	3.30%
Бодлогын хүү	2020.V	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.V	8.93%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.V	11.20%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.V	4.48%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.V	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.V	10.41%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 38 компанийн 248.5 сая төгрөгийн 1,086,454 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Монгол савхи” /MSE: UYN/ компанийн хувьцаа 31.53%-аар буюу хамгийн ихээр өсөж 680.00 төгрөг хүрч хаагдсан бол “Булган гурил тэжээл” /MSE: GTJ/ компанийн хувьцаа 14.99%-аар буурч 590.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК-ийн 37.7 сая төгрөгийн 377 ширхэг үнэт цаас арилжаалагдав.

07-р сарын 10-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,506.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,427.63 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.42%-аар буурсан байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	286.23	
Зах зээлийн үнэлгээ	2,506,372.06	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,427.63	-0.42% ▼
MSE I индекс	7,943.49	-0.97% ▼
MSE II индекс	7,380.41	-2.49% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Эрдэнэ ресурс девелопмент корп	59,342	43,809,620
Инвекор ББСБ	11,802	29,668,420
Говь	100,225	19,372,251
Бодь даатгал	163,465	18,419,601
Хөнгөн бетон	77,148	17,906,051

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монгол савхи	680.00	31.53% ▲
Махимпекс	3,130.00	29.34% ▲
Жуулчин дютти фрий	79,950.00	14.21% ▲
Эрдэнэ ресурс девелопмент корп	750.00	13.64% ▲
Бодь даатгал	112.78	8.49% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Булган гурил тэжээл	590.00	-14.99% ▼
Мерекс	12.00	-14.29% ▼
Ард санхүүгийн нэгдэл	1,130.00	-11.65% ▼
Ард кредит ББСБ	60.11	-11.15% ▼
Мон-ит булигаар	5,000.00	-9.09% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
БиДиСек	143,092,396.30
Ард секюритиз	69,033,329.67
Ти Ди Би Капитал	61,841,093.74
Бумбат-Алтай	45,325,580.11
Стандарт инвестмент	30,809,118.20

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Y (сая.төг)
АПУ	548.99	584,225
Таван толгой	5,530.00	291,239
МИК холдинг	12,990.00	269,014
Инвекор ББСБ	2,513.00	180,252
Говь	196.19	153,050

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	20	2,000,000	100,000	100,000	52	17%
2	LNBO-BD-19/06/21-C0008-17	326	32,600,000	100,000	100,000	52	17%
3	LNBO-BD-19/06/21-C0008-17	1	100,000	100,000	100,000	52	17%
4	LNBO-BD-19/06/21-C0008-17	30	3,000,000	100,000	100,000	52	17%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-нд ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-нд ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-ны ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-нд ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-нд ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-ны ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-ны ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-өөс
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ээс
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ээс
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-ний ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-ны ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ээс
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-нд ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-аас
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-оос
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-нд ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-ний ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-ны ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-ны ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-нд ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-нд ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-ны ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-ны ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-нд ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ээс
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ээс
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-ны ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-ний ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-ний ДОТОР
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-ний ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-ний ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 20-р зүйлийн 20.2-д заасныг үндэслэн гаргасан гүйцэтгэх захирлын 2020 оны 7-р сарын 7-ны өдрийн А/51 тоот тушаалын дагуу бүртгэлтэй хувьцаат компанийн үнэт цаасны ангиллыг шинэчлэн тогтоолоо. МХБ-ийн бүртгэлтэй компаниудаас үйл ажиллагаа, ашиг орлого, арилжааны идэвх, компанийн засаглалаараа тэргүүлэгч компаниудыг хамруулсан I дүгээр ангилалд "Түмэн шувуут" ХК, Монос хүнс" ХК, "Хөвсгөл алтан дуулга" ХК-иуд шинээр дэвшин орсон бол бүртгэлийн II дугаар ангилалд "Инвескор ББСБ" ХК, "Тээвэр-Дархан" ХК, "Монгол даатгал" ХК, "Монгол шевро" ХК, "Нэхээсгүй эдлэл" ХК зэрэг компаниуд шинээр орлоо. Харин бүртгэлийн II дугаар ангиллаас "Мерекс" ХК, "Нако түлш" ХК, "Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК, "Хөх ган" ХК-иуд ангилал буурч III дугаар ангилалд орсон байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

"Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн" /MSE: ERDN, TSX: ERD/ ХК шинэ өрөмдлөгийн мэдээлэл ирүүллээ.

"Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн" /MSE: ERDN, TSX: ERD/ ХК ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") өөрийн эзэмшлийн Баян Хөндий Алтны Төслийн талбайн Зүүн-Өмнөд Мидфийлд бүсэд гүйцэтгэж буй өрөмдлөгийн хөтөлбөрийн тухай мэдээлэл хүргэж байна.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал ноён Петер Акерли "Баян Хөндий ордын зүүн өмнөд Мидфийлд хэсгийн шинэ бүсэд хийсэн өрөмдлөгийн ажлын үр дүнд газрын дөт гүнд 582 г/т алтны агуулга бүхий 1 метр багтаасан 126 г/т алтны агуулга бүхий 5.5 метрийн интервал илрүүлснийг танилцуулж байгаадаа бид баяртай байна. Мөн эхний цооногоос хойд зүгт 40 метрийн зайд хийсэн өрөмдлөгт 338 г/т алтны агуулга бүхий 1 метр багтаасан 26 г/т алтны агуулга бүхий 15 метрийн интервал огтолсон. Энэхүү талбай нь одоогоор ил уурхайн хаягдал буюу бага агуулгатай материалын ангилалд багтсан бөгөөд энэ талбайд шинэ өндөр агуулга бүхий бүс нээснээр ашиглалтын эхэн үед нөөцийг тэлэх чухал ач холбогдолтой гэж бид үзэж байна.

Бид Баян Хөндийг олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлж, ирэх долоо хоногуудад төслийн эцсийн ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулахаар төлөвлөж байна. Мөн өнгөрсөн 6 сарын хугацаанд бид Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн талбайд өндөр агуулга бүхий интервалууд огтолж, хэтийн төлөв бүхий Хар Морь талбайг нээн илрүүлснээр Хөндий Алтны Дүүргийн боломжийг харуулсан. Страйкер болон Хар Морь талбайд хийгдсэн хөтөлбөрүүдийн нэмэлт үр дүнгүүд хүлээгдэж байгаа ч хэд хэдэн нүдэнд үзэгдэх алт тохиолдлоо. Бид эдгээр зорилтот бүсүүдэд нэмэлт хайгуулын өрөмдлөгийн төлөвлөгөө боловсруулж, өнөөгийн тодорхойлогдсон нөөцийг тэлснээр Баян Хөндий алтны уурхайг өргөтгөх боломжуудыг тодорхойлох болно." гэж мэдэгджээ.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

"Монгол даатгал" /MSE: CHE/ ХК-ийн үнэт цаасны арилжааг зогсоолоо.

"Монгол даатгал" /MSE: CHE/ ХК-ийн товчилсон нэршил өөрчлөхтэй холбоотойгоор гаргасан хүсэлтийн дагуу СЗХ-ны Улсын байцаагчийн 2020 оны 7-р сарын 6-ны өдрийн 95 тоот албан шаардлагын дагуу тус компанийн үнэт цаасны арилжааг 2020 оны 7-р сарын 7-ны өдрөөс эхлэн түр зогсоохоор боллоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

"Дархан нэхий" /MSE: NEH/ ХК-ийн үнэт цаасны арилжааг зогсоолоо.

"Дархан нэхий" /MSE: NEH/ ХК-ийн 2019 оны 3-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн нэгж хувьцааг 1000 хуваахаар шийдвэрлэж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн бөгөөд СЗХ-ны 2020 оны 7-р сарын 8-ны өдрийн хурлаар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн тул Хорооны улсын байцаагчийн 2020 оны 7-р сарын 8-ны өдрийн 96 тоот албан шаардлагын дагуу "Дархан нэхий" /MSE: NEH/ ХК-ийн үнэт цаасны арилжааг 2020 оны 7-р сарын 9-ны өдрөөс эхлэн түр зогсоохоор боллоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

"Лэндмн ББСБ" /MSE: LEND/ ХК-ийн ТУЗ-ийн шийдвэр.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.18, 80-р зүйлийн 80.2, СЗХ-ний дарга, Сангийн сайдын 2015 оны 144/125 тоот хамтарсан тушаалаар баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ийн 3-р зүйлийн 3.6.4, "Лэндмн ББСБ" /MSE: LEND/ ХК-ийн дүрмийн 9-р зүйлийн 9.6.23-ийг үндэслэн ТУЗ-өөс чанаргүй болж муудсан 115 сая төгрөгийн зээл болон 15 сая төгрөгийн төлөгдөөгүй шимтгэлийн авлагыг компанийн эрсдэлийн сангаас хаах шийдвэр гаргажээ.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Standard & Poor's агентлаг 2020 оны 7-р сарын 9-ны өдөр Монгол улсын зээлжих зэрэглэлийг "В" хэвээр үлдээж, төлөвийг "тогтвортой" гэж үнэлжээ.

S&P агентлаг үнэлгээндээ COVID-19 цар тахалтай холбоотой түүхий эдийн зах зээл удаашран эдийн засгийн өсөлт саарч байгаа ч БНХАУ-ын эдийн засгийн сэргэлтийн нөлөөгөөр ирэх жилүүдэд эрчимтэй сэргэнэ хэмээн үзжээ. Түүнчлэн МАН дахин сонгогдсоноор дэлхийн эдийн засаг сэргэж эхэлмэгц төсөв, санхүүгээ нэгтгэх хүчин чармайлт үргэлжилнэ гэж харж байгаагаа илтгэсэн ба Монгол Улсын төсөв, ер болон гадаад нөхцөл байдал 2021 оноос сайжирна гэж үзэж байгаагаа онцолсон байна.

Эх сурвалж: S&P Global Rating



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

2020 оны эхний 6 сарын дүнгээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 5,288.3 сая ам.доллар болж 2019 оны мөн үеэс 1,544.5 сая ам.доллар буюу 22.6%-аар буурчээ. Экспортын дүн импортын дүнгээс 368.0 сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа.

Экспортод 2,828.2 сая ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28.2%-аар буурсан байна. Экспортын барааны нийт дүнд эрдэс бүтээгдэхүүн 2,020.6 сая ам.доллар буюу 71.4%; сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс бүлэгт багтах барааны экспорт 607.1 сая ам.доллар буюу 21.5%; арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл 5.8 сая ам.доллар буюу 0.2%; нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн 118.4 сая ам.доллар буюу 4.2%-ийг тус тус эзэлж эдгээр нь нийт экспортын дүнгийн 97.3%-ийг эзэлж байна.

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголбанк 2020 оны 6-р сард 2.3 тонн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 10.8 тонн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4.8 тонноор өссөн үзүүлэлт юм. Монголбанкны нийт худалдан авсан 10.8 тонн үнэт металлын 9.1 тонн нь алт, 1.7 тонн нь цагаан мөнгө байна.

2020 оны 6-р сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 63.9 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 81.9 кг үнэт металл худалдан аваад байна. Он гарснаас хойш орон нутаг дахь Монголбанкны 2 хэлтэс нийт 565 кг үнэт металл худалдан авлаа.


Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 6-р сард 156,422.38 төгрөг байлаа.

Эх сурвалж: Монголбанк



ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Нэрлэсэн ДНБ нь 1990 оноос хойш хурдацтай өссөн бөгөөд эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан харуулбал Уул уурхай олборлолт, Хөдөө аж ахуй, Боловсруулах үйлдвэрлэл, Худалдаа болон Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа нь ДНБ-ий дийлэнх хэсгийг бүрдүүлж байна.

Бүтцийн хувьд 2004 он хүртэл ДНБ-ий бүтцийг Хөдөө аж ахуйн салбар дийлэнх хэсгийг бүрдүүлж байсан бол 2004 оноос хойш Уул уурхайн салбар тэргүүлж эхэлсэн байна. 2019 оны байдлаар Нэрлэсэн ДНБ-ий 23.8%-ийг Уул уурхай, олборлолт, 11.0%-ийг Хөдөө аж ахуй, 9.6%-ийг Боловсруулах үйлдвэрлэл, 9.2%-ийг Худалдаа, 5.2%-ийг Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа бүрдүүлж байна.

Аж үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэлийг Уул уурхай, олборлох аж үйлдвэр, Боловсруулах үйлдвэр, Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж гэж 3 хувааж авч үздэг бөгөөд дийлэнх хэсгийг Уул уурхайн, олборлох аж үйлдвэр эзэлсээр байна. Уул уурхайн, олборлох аж үйлдвэр 2003 онд Нийт аж үйлдвэрлэлийн 54.9%-ийг бүрдүүлж байсан бол 2019 оны байдлаар 71.7%-ийг бүрдүүлж байна.

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.